



Гүйцэтгэлийн аудитын тайлан /ТӨСӨЛ/

2022 оны 4 дүгээр сар

**АУДИТЫН СЭДЭВ: Орон нутгийн төсвийн
2021 оны хөрөнгө оруулалтын
төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн**

АГУУЛГА

<p><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газар</p> <p>Дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал</p> <p>Аудитын менежер Д.Гансүх</p> <p>Ахлах аудитор С.Шийлэгмаа</p> <p>Аудитор Б.Авидцэрэн, П.Норпил</p> <p>2022 оны 4 дүгээр сар</p> <p>Уг тайланг www.audit.mn хаягаас үзнэ үү.</p> <p>Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70323833 дугаарын утас, 70323253 дугаарын факсаар харилцана уу</p> <p>ХАЯГ:</p> <p>(Өвөрхангай аймаг, Арвайхээр сум, 5 дугаар баг, Нутгийн удирдлагын ордон 405 тоот)</p>	<p>Товчилсон үгийн тайлбар</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй</p> <p>Бүлэг А</p> <p>Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр нөлөө муутай байна</p> <ul style="list-style-type: none">• Тайлант оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаатай батлагдсан ч дунд хугацааны бодлого төлөвлөлтөөр хийгдэх хөрөнгө оруулалтаас тусгаагүй байна• Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 58.1 хувьд нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн төсөл арга хэмжээг баталжээ• Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахдаа, олон нийтийн саналд үндэслэхгүй, хэрэгжүүлэх эрэмбэ тогтоохгүй байна• Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна• Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталсан байна• Хөрөнгө оруулалтын зардлаар баталсан нийт төсөл, арга хэмжээний 58.5 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээ эзэлж байна <p>Бүлэг Б</p> <p>Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна</p> <ul style="list-style-type: none">• Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрхийг шилжүүлжээ• Төсөл, арга хэмжээний ихэнхийг тайлант онд бүрэн хэрэгжиж болохуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна• Зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд шаардлага хангасан гүйцэтгэгчийг шалгаруулсан ч зарим худалдан авалтад сонгон шалгаруулалт зарлаагүй байна• Худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь үнэн зөв гаргажээ• Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгэжээ
---	---

- Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээнд хэрэгжүүлсэн захиалагчийн хяналт үр нөлөөтэй байна
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хэрэгжсэн ч зохиогчийн зүгээс хяналт тавиагүй байна
- Засварын ажлын захиалагчийн хяналтаар илрүүлсэн зөрчлийг барагдуулж ажиллажээ
- Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь олгосон боловч хөрөнгө оруулалтын бус шинжтэй арга хэмжээний санхүүжилтийг ихэвчлэн урьдчилж олгосон байна
- Хөрөнгө оруулалтаар бий болсон автомашин, их засварыг тухайн байгууллагын бүртгэлд тусгаж, ашиглалтад оруулжээ
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч зарим зөрчил давтагдсан байна

Дүгнэлт

Зөвлөмж

Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал

Саналд өгсөн тайлбар

Хавсралтууд

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГА	Гүйцэтгэлийн аудит
ГАГ	Гүйцэтгэлийн аудитын газар
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ШТА	Шууд тайлагнах аудит

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны “Аудитын сэдэв батлах тухай” 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2022 оны “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” А/12 дугаар тушаалаар баталсан аудитын сэдэв, Монгол Улсын Ерөнхий Аудиторын баталсан “Улс, орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” сэдэвт, ӨВА-2022/16-14-ШТА-ГА кодтой аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүнд аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэв. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо үр нөлөөтэй эсэх
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх

Аудитын хамрах хүрээ:

Энэхүү аудитыг Өвөрхангай аймгийн Арвайхээр, Хужирт, Гучин-Ус зэрэг сумд, аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар, Орон нутгийн өмчийн газар, аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ зэрэг байгууллагыг хамруулан тэдгээрийн эрх зүйн үндэслэл, гүйцэтгэсэн ажлын тайлан мэдээ, хөрөнгө оруулалтын үр дүн, хэрэгжилтийн талаарх тайлан, судалгаа, мэдээлэлд үндэслэн бодит байдлыг газар дээр нь үзэж, холбогдох бусад баримт материалуудад тулгуурлан аудитыг гүйцэтгэв.

Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт:

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС-100, АДБОУС-300, АДБОУС-3000-д нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит, Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим, арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ын дагуу холбогдох албан тушаалтанд ярилцлага хийх, тайлбар, тодруулга авах, шалгагдагч байгууллагаас авсан судалгаа, санал асуулга, мэдээлэл, нотлох зүйлсийг нягтлан шалгах, дүн шинжилгээ хийх, тулган баталгаажуулах, анхны баримтаас хөөн шалгах, бодит байдал дээр оршин байгааг үзэх, ажиглалт хийх зэрэг аудитын горимуудыг ашиглав.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- ✓ Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- ✓ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- ✓ Барилгын тухай хууль
- ✓ Иргэний хууль

- ✓ Дээрх хуулиудыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан гаргасан УИХ, Засгийн газрын тогтоол, аймгийн ИТХ, Засаг даргын Захирамж, бусад эрхийн актууд
- ✓ Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- ✓ Сангийн сайдын 2018 оны 281 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”
- ✓ Барилга, хот байгуулалтын сайдын 2018 оны “Аргачлал батлах тухай” 33 дугаар тушаал
- ✓ Холбогдох бусад хууль, тогтоомж, эрхийн актууд

Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Өвөрхангай аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор О.Батжаргал удирдаж, үе шатны болон чанарын хяналтыг аудитын менежер Д.Гансүх хэрэгжүүлж, гүйцэтгэлийн багийн ахлах аудитор С.Шийлэгмаа, аудитор Б.Авидцэрэн, П.Норпил нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 3 дугаар сарын 21-ний өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудитораар баталгаажуулан Нийслэлийн ТАГ, аймгийн ИТХ, Засаг дарга, Аймгийн ХОХБТХ, ОНӨГ, ГХБХБГ-т 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр хүргүүлээ.

Аудитаар 33.0 сая төгрөгийн 1 албан шаардлага бичиж, 33.0 сая төгрөгийн үр өгөөж тооцож, 6 зөвлөмж өгөв.

Ерөнхий мэдээлэл

Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/07 дугаар тогтоолоор 2021 онд Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын жагсаалтыг баталсан бөгөөд төсөвт тодотгол хийсэн 2021 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 05/06 ба 05/07 тогтоолоор тус тус өөрчлөлт оруулан баталсан байна.

Аймгийн 2021 оны төсөв батлах тухай 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/07 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад барилга байгууламж барих 1 төсөлд 150.0 сая, их засварын 1 төсөлд 80.0 сая, тээврийн хэрэгслийн засвар шинэчлэлийн 2 төсөлд 311.0 сая, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус 2 арга хэмжээнд 485.0 сая төгрөг, нийт 6 төсөл, арга хэмжээнд 1,026.0 сая төгрөгийг зарцуулахаар баталжээ.

Аймгийн 2021 оны төсөвт өөрчлөлт оруулах тухай 2021 оны 7 дугаар сарын 08-ны өдрийн 05/06 дугаар тогтоолоор 2 төслийн зориулалтыг өөрчлөн, мөн өдрийн 05/07 дугаар тогтоолоор их засварын 1 төсөлд 60.0 сая төгрөг нэмж баталснаар нийт 7 төсөл арга хэмжээнд 1,086.0 сая төгрөг эцэслэн батлагджээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 956.8 сая төгрөгийг зарцуулж, санхүүжүүлж амжаагүй үлдэгдэл болох 129.2 сая төгрөгийг техник хяналт, барьцаа дансанд төвлөрүүлжээ.

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 58.5 ХУВЬ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУС ШИНЖТЭЙ АРГА ХЭМЖЭЭ БАЙНА.

А. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт үр нөлөө муутай байна

А.1. Орон нутгийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх ажил хангалтгүй байна

А.1.1 Тайлант оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөө нь аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдаатай батлагдсан ч дунд хугацааны бодлого төлөвлөлтөөр хийгдэх хөрөнгө оруулалтаас тусгаагүй байна

Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан боловсруулсан *Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03/02, 03/03 тогтоолоор, Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөг ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 03/04 тогтоолоор баталжээ.*

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжүүлэхээр баталсан 1086.0 сая төгрөгийн өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний 41.5 хувь буюу хөрөнгө оруулалтын шинжтэй 4 ажил нь *Аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан байна.*

Харин аймгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийн дунд хугацааны баримт бичгүүд болох *Өвөрхангай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт төлөвлөсөн арга хэмжээнээс тайлант оны хөрөнгө оруулалтын зардалд тусгаж төлөвлөөгүй байна.*

А.1.2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний 58.1 хувьд нь хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн төсөл арга хэмжээг баталжээ

Дараах 631.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ нь төсвийн байгууллагуудын төлөвлөгөөний төсөлд санал ирүүлсэн, тухайн хэрэглэгчийн хэрэгцээ шаардлагад үндэслэж төлөвлөгдсөн байна. Үүнд:

- ✓ *Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн гадна засварын зардал 80.0 сая,*
- ✓ *Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын засварын үлдэгдэл санхүүжилт 60.0 сая,*
- ✓ *Сумдын төрийн албаны автомашины засвар, шинэчлэл хийх 200.0 сая,*
- ✓ *Багийн дарга нарыг унаажуулах 111.0 сая, /Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан Аймгийн ИТХ-ын 05/07 тоот тогтоолоор Засаг дарга нарыг компьютер, техник төхөөрөмжөөр хангах зардал болгож өөрчилсөн/*
- ✓ *Хужирт сумын төрийн албан хаагчдын албан хэрэгцээний байр барих /сумын ЗДТГ/ 150.0 сая, /Цаг үеийн шаардлагаар батлагдсан Аймгийн ИТХ-ын 05/06 тоот тогтоолоор "Ковид-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээний зардал" болгон өөрчилсөн/*
- ✓ *Хөрөнгө оруулалтын шинжгүй боловч Төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардлаас:*
 - *Улаан загалмайн аймгийн хороонд олгосон хүмүүнлэгийн арга хэмжээний зардал 15.0 сая,*

- Бандида ламтан санд олгосон Гэгээнтний сургалтын төлбөр 15.0 сая төгрөг.

Эдгээр зардлууд нь нийт батлагдсан төсвийн 58.1 хувийг эзэлж байна.

А.1.3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөгөөнд тусгахдаа, олон нийтийн саналд үндэслэхгүй, хэрэгжүүлэх эрэмбэ тогтоохгүй байна

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнүүдийг хэрэгцээ шаардлага, ач холбогдлын дарааллаар эрэмбэлж төлөвлөгөөнд тусгахгүй, олон нийтээс санал авахгүй байна.

А.2. Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой байдлаар санхүүжилтийг баталж байгаа боловч үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна

А.2.1. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө төсөвлөлтийн шаардлагыг хангаагүй байна

Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг аймгийн төсөвт тусган батлуулахдаа төсөвлөлтийн наад захын шаардлагыг хангуулахгүй, орон нутагт хэрэгцээ шаардлагатай хөрөнгийг бий болгохгүй зардлыг ихээр оруулж байна.

Энэ нь Сангийн сайдын 2019 оны 282 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ыг бүхэлд нь мөрдөж ажиллахгүй, журмын 3 дахь хэсгийн 3.2.1-д “Төсөл арга хэмжээний саналыг аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр судлан шинжилж, эрэмбэлэх, үнэлэх”, 3.2.2-т “Төсөл, арга хэмжээний саналд энэ журамд заасны дагуу судалгаа хийж, эрэмбэлэн улсын төсвөөр хэрэгжүүлэх нэн тэргүүний ач холбогдолтой төсөл, арга хэмжээнүүдийг тодорхойлох, жагсаалт гаргах” гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Түүнчлэн аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвлөлт нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-т: “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасантай нийцэхгүй байна. Тухайлбал:

Төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардал 85.0 сая төгрөгийн хөрөнгийг төсөвт тусгаж батлахдаа ямар зориулалтаар зарцуулах нь тодорхойгүй байжээ. Цагдаагийн газраас 2021 оны 3 дугаар сард ирүүлсэн хүсэлтийг үндэслэн 3 дугаар сарын 22-ны өдөр баталсан А/127 тоот захирамжаар 10.8 сая төгрөг, Шүүхийн шинжилгээний албанаас 7 дугаар сард ирсэн албан бичгийг үндэслэн 7 дугаар сарын 09-ний өдөр гарсан А/362 тоот захирамжаар 16.8 сая төгрөг, 6 дугаар сарын 23-ны өдөр А/309 тоот захирамж баталж Хархорины хорих ангид 20.0 сая төгрөг олгосон байна.

Хөрөнгө оруулалтын зардлаас санхүүжүүлэхээр баталсан зарим төсөлд дутагдсан хөрөнгийг оны дундуур төсөвт тодотгол хийхдээ Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхээр шийдвэрлэж байгаа нь эдгээр хөрөнгө оруулалтын бус шинжтэй арга хэмжээний төсвийг хуулиар хүлээн зөвшөөрсөн ангиллын зардалд оруулан төлөвлөж батлуулах боломжийг бий болгож байна.

А.2.2. Төсөл, арга хэмжээг хугацаандаа хэрэгжих боломжтой байдлаар тооцож санхүүжилтийг баталсан байна

Хөрөнгө оруулалтын зардлаар санхүүжүүлэхээр баталсан Сумдын төрийн албаны автомашины засвар, шинэчлэл хийх 200.0 сая төгрөгийн зардал нь аймгийн болон

сумдын ЗДТГ-т 4 автомашин худалдан авах зориулалттай батлагдсан боловч төсөв хүрэлцээгүйн улмаас дахин захирамж гаргаж, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 43.5 сая төгрөг зарцуулан хэрэгжүүлжээ.

Бусад төсөл арга хэмжээг хугацаандаа бүрэн хэрэгжих боломжтой байдлаар санхүүжилтийг баталсан байна.

Хүснэгт 1

Аймгийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан төсөл, арга хэмжээ

/сая төгрөгөөр/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн
Их засвар		
1	Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн гадна засварын зардал	80.0
2	Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын засварын үлдэгдэл санхүүжилт	60.0
Автомашин, тоног төхөөрөмж худалдан авах зардал		
3	Сумдын төрийн албаны автомашины засвар, шинэчлэл хийх	200.0
4	Багийн Засаг дарга нарын компьютер, техник төхөөрөмжөөр хангах	111.0
Арга хэмжээний зардал		
5	Ковид-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээний зардал	150.0
6	Аймгийн 90 жилийн ойг угтсан бэлтгэл ажил, зохион байгуулах арга хэмжээний зардал	400.0
7	Төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардал	85.0
НИЙТ ДҮН		1,086.0

А.2.3. Хөрөнгө оруулалтын зардлаар баталсан нийт төсөл, арга хэмжээний 58.5 хувийг хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээ эзэлж байна

Тухайн оны аймгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг анх батлахдаа хөрөнгө оруулалтын шинж чанартай бус дараах төсөл арга хэмжээг төлөвлөж батлуулсан байна.

Үүнд:

- Аймгийн 90 жилийн ойг угтсан бэлтгэл ажил, зохион байгуулах арга хэмжээний зардал 400.0 сая төгрөг,
- Төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардал 85.0 сая төгрөг

Батлагдсан төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах үед хөрөнгө оруулалтын шинжтэй, 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төслийг “Ковид-19 цар тахалтай тэмцэх арга хэмжээний зардал” хөрөнгө оруулалтын бус шинж чанартай арга хэмжээ болгон өөрчилсөн нь тухайн үеийн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан онцгой арга хэмжээ болжээ.

Тайлант онд батлагдан хэрэгжсэн хөрөнгө оруулалтын бус шинж чанартай 3 арга хэмжээ нь нийт хөрөнгө оруулалтын зардлын 58.5 хувийг эзэлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-д “Хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шинжих хөрөнгийн зардлыг”, 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад жил бүр хөрөнгө оруулалтын бус шинжтэй арга хэмжээг оруулан баталж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д: “Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно”, 4.1.24-т: “хөрөнгө оруулалт” гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэж заасан үндсэн тодорхойлолтыг зөрчиж, уг зардлын гол утгыг алдагдуулахад хүргэж байна.

Б. Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байна

Б.1. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан боловч зарим худалдан авалтад сонгон шалгаруулалт зарлаагүй байна

Б.1.1. Төсөл, арга хэмжээг хэрэгжих боломжтой хугацаанд эрхийг шилжүүлжээ

Аймгийн Засаг дарга нь сумдын ЗДТГ-т автомашин худалдаж авах 200.0 сая төгрөгийн төслөөс 140.0 сая төгрөгийн эрхийг 2021.01.22-ны өдрийн А/27 тоот захирамжаар дараах сумдын Засаг даргад шилжүүлсэн байна. Үүнд:

- Хужирт сум 50.0 сая,
- Гучин-Ус сум 50.0 сая,
- Нарийнтээл сум 40.0 сая

Мөн оны 4 дүгээр сарын 07-ны өдрийн А/168 тоот захирамжаар Хужирт сумын ЗДТГ-т 12.0 сая, Нарийнтээл сумын ЗДТГ-т 6.5 сая, аймгийн ЗДТГ-т 25.0 сая төгрөгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас нэмж олгохоор шийдвэрлэжээ.

Эрх шилжүүлсэн захирамжид эдгээр арга хэмжээний худалдан авах ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зохион байгуулж ажиллахыг тус сумдын Засаг дарга нарт даалгасан байна.

Б.1.2. Төсөл арга хэмжээг тайлант онд бүрэн хэрэгжиж болохуйцаар худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна

Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих 4 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагааг аймгийн Орон нутгийн өмчийн газар зохион байгуулсан ба гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог аймгийн Засаг даргын захирамжаар 5-7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулжээ. 3 төсөл, арга хэмжээний Үнэлгээний хороо байгуулах хугацааг 8-180 хоногоор хэтрүүлснээс шалтгаалж гэрээ байгуулах эрх олгох хугацааг 14-220 хоногоор хэтрүүлсэн байна.

Үүнээс “Багийн дарга нарыг компьютер техник тоног төхөөрөмжөөр хангах” төслийн үнэлгээний хороог 7 дугаар сарын 09-ний өдөр байгуулж, тендер шалгаруулалт 9 дүгээр сарын 06-ны өдөр явагдсан ба оролцогчоос Сангийн яаманд гомдол гаргасан тул уг ажиллагааг түдгэлзүүлж, гомдлыг хянасны дараа сонгон шалгаруулалтыг дахин явуулснаар гэрээ байгуулах эрхийг 10 дугаар сарын 11-ний өдөр олгожээ. Энэ төсөл нь тухайн ондоо багтаж хэрэгжээгүй.

Бусад 3 төслийн худалдан авах ажиллагаа нь эдгээр төсөл арга хэмжээ тайлант онд багтаж хэрэгжих боломжийг хангахуйцаар зохион байгуулагджээ.

Б.1.3. Зохион байгуулсан худалдан авах ажиллагаанд шаардлага хангасан гүйцэтгэгчийг шалгаруулсан ч зарим худалдан авалтад сонгон шалгаруулалт зарлаагүй байна

Орон нутгийн өмчийн газраас зохион байгуулсан 3 төслийн худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу явагдаж, шаардлага хангасан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна.

Багийн дарга нарыг компьютер техник тоног төхөөрөмжөөр хангах 111.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төслийн тендерт хамгийн бага үнийн санал ирүүлсэн Монтех дистрибьюшн ХХК-ийн нийлүүлэхээр санал болгосон Dell Брэндийг тендерийн баримт бичигт НР болон түүнтэй дүйцэхүйц гэж зарласнаас зөрүүтэй, чанарын шаардлага хангахгүй гэж үзэн илүү өндөр үнэтэй Би Си Ти ХХК-ийг шалгаруулсан байна. Гэвч "Монтех дистрибьюшн" ХХК нь Сангийн яаманд гомдол мэдүүлснээр тендерүүдийг дахин үнэлж, тус компанийг шалгаруулжээ.

Харин нэр бүхий 3 суманд эрх шилжүүлсэн Сумдын төрийн албаны автомашины засвар, шинэчлэл хийх 200.0 сая төгрөгийн арга хэмжээний 140.0 сая төгрөгийн худалдан авах ажиллагааг эрх хүлээн авсан сумд зохион байгуулсан. Эдгээр худалдан авалтад нээлттэй тендер шалгаруулалт зарлах ёстой байсан боловч зөвхөн Гучин-Ус сумын Засаг дарга цахим тендер зарлаж, гүйцэтгэгчийг хууль журмын дагуу сонгон шалгаруулсан байна.

Нарийнтээл, Хужирт сумын ЗДТГ-ын автомашиныг худалдан авахдаа тухайн үеийн цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан үйлдсэн аймгийн онцгой комиссын хуралдааны тэмдэглэлийг үндэслэн шууд худалдан авалт хийжээ. Аймгийн 90 жилийн ойг угтсан бэлтгэл ажил, зохион байгуулах арга хэмжээний зардал 400.0 сая төгрөгийн төслийн хүрээнд санхүүжилт хийсэн дурсгалын хөшөөний гүйцэтгэгчийг мөн сонгон шалгаруулалт зарлахгүйгээр шууд гэрээ байгуулсан байна.

Б.1.4. Худалдан авах ажиллагааны тайланг хугацаанд нь үнэн зөв гаргажээ

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.5-д: "Тухайн жилд худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний тайланг захиалагч тухайн жилийн 12 дугаар сарын 1-ний дотор төсвийн ерөнхийлөн захирагчид, ерөнхийлөн захирагч нь дараа оны 1 дүгээр сарын 15-ны дотор төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана" гэж заасны дагуу тайланг гаргаж Сангийн яаманд хүргүүлэн, шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байна.

Б.2. Захиалагч хөрөнгө оруулалтын шинжтэй ажлуудын гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна

Б.2.1. Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээг хугацаанд нь үр дүнтэй гүйцэтгэжээ

Дараах төсөл арга хэмжээнүүд хугацаандаа үр дүнтэй хэрэгжсэн байна. Үүнд:

- Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн гадна засварын ажлын гүйцэтгэгчээр "Кенорда" ХХК шалгаран БЗ-08/2021-ӨВАОНӨГ/202112004 тоот гэрээг 6 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан ба гадна фасадын засварын ажилд тохиромжгүй цаг агаарын нөхцөлөөс шалтгаалж ажлын хугацаа сунгах БЗ-08/2021-ӨВАОНӨГ/202112004+1 гэрээг 7

дугаар сарын 30-ны өдөр байгуулжээ. 8 дугаар сарын 24-ний өдөр улсын комисс ажиллаж, засварын ажлыг сайн дүнтэй хүлээн авсан байна.

- Аймгийн Засаг даргын тамгын газрын барилгын засварын ажил нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын 200.0 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдсэн бөгөөд дутагдсан санхүүжилтийн 60.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаас олгосон.

- Сумдын төрийн албаны автомашины засвар, шинэчлэл хийх төсөлд санхүүжилт хүрэлцээгүйн улмаас Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 43.5 сая төгрөг нэмж зарцуулан, техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангасан худалдан авалт хийсэн байна.

Харин Багийн Засаг дарга нарыг компьютер, техник төхөөрөмжөөр хангах 111.0 сая төгрөгийн өртөгтэй төслийн худалдан авах ажиллагаа удааширсны улмаас гэрээ байгуулах эрхийг 10 дугаар сарын 11-ний өдөр олгосон байна. Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан тогтоосон хилийн хорио цээрийн улмаас уг төслийн гэрээний хугацааг сунгасан ба тайлант ондоо багтаж хэрэгжээгүй ч гэрээний хугацаанд гүйцэтгэж, хүлээлгэн өгчээ.

Б.2.2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнүүдэд хэрэгжүүлсэн захиалагчийн хяналт үр нөлөөтэй байна.

Барилгын их засварын ажилд захиалагчийн хяналтыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар гэрээний дагуу хэрэгжүүлж ажилласан байна. Засварын ажлын явцад хяналтыг тогтмол тавьж, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангуулжээ.

Автомашин нийлүүлэх төслийн хэрэгжилтэд тухайн төсвийн байгууллага шууд хяналт тавьж хөрөнгийг хүлээн авсан байна.

Тоног төхөөрөмж нийлүүлэлтэд тавих хяналтыг ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс хуваарийн дагуу хэрэгжүүлж байна.

Б.2.3. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд тавих захиалагчийн хяналт хэрэгжсэн ч зохиогчийн зүгээс хяналт тавиагүй байна

Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтэд тавих захиалагчийн хяналт үр нөлөөтэй хэрэгжсэн байна. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын гадна фасад, дотор заслын ажлын зураг төсөв боловсруулах ажлын гүйцэтгэгчээр “Арвай проект” ХХК ажилласан ч их засварын ил, далд ажлын актыг баталгаажуулахад зохиогчийн хяналт хийгдээгүй байна.

Б.2.4. Засварын ажлын захиалагчийн хяналтаар илрүүлсэн зөрчлийг барагдуулж ажиллажээ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын барилгын их засварын ажлыг хүлээн авах улсын комиссын гишүүдийн зүгээс илрүүлсэн 7 зөрчлийг гүйцэтгэгч компани арилгаж, тайланг бичмэл болон зураг хэлбэрээр гаргаж ирүүлжээ.

Б.3. Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна

Б.3.1. Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн хугацаанд нь олгосон боловч хөрөнгө оруулалтын бус шинжтэй арга хэмжээний санхүүжилтийг ихэвчлэн урьдчилж олгосон байна

Аймгийн орон нутгийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгожээ. Нийт батлагдсан 1086.0 сая төгрөгийн санхүүжилтээс 956.8 сая төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна.

Үүнээс дараах төсөл арга хэмжээнүүд бүрэн хэрэгжиж, санхүүжилтийг бүрэн олгосон байна. Үүнд:

- *Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн гадна засвар* 75.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан боловч бодит гүйцэтгэл 75.8 сая төгрөг болж, зураг төсвийн үнэ 2.2 сая төгрөгийг олгосноор нийт гүйцэтгэл 78.0 сая төгрөг болжээ. Тендерийн хэмнэлт 2.0 сая төгрөгийг орон нутгийн төсвийн ерөнхий орлогын дансанд бус, техник хяналт, барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.
- *Сумдын төрийн албаны автомашины засвар, шинэчлэл хийх* 200.0 сая төгрөгөөс сумдад эрх шилжүүлсэн 140.0 сая төгрөгийн санхүүжилтийг тухайн сумдад 2 дугаар сарын 08-ны өдөр олгосон бол аймгийн ЗДТГ-ын автомашиныг тендерт шалгарч гэрээ байгуулсан гүйцэтгэгчээс хүлээн авсан актыг үндэслэн 3 дугаар сарын 15-ны өдөр шилжүүлсэн байна.
- *Ковид-19 цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний зардал* болгон өөрчилж баталсан 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг хийхдээ аймгийн хэмжээнд цар тахлын дэгдэлт өндөр байсан аймгийн төв болон сумдад ажиллуулж байсан тусгаарлах байруудын бодит гүйцэтгэлд тулгуурлан бүрэн олгосон байна.
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн *Аймгийн ЗДТГ-ын их засварын үлдэгдэл* санхүүжилтийг орон нутгаас олгохоор нэмэлтээр баталсан 60.0 сая төгрөгийг тухайн ажлын бодит гүйцэтгэл, ажил хүлээн авсан гэрээнд үндэслэн олгожээ.
- *Багийн дарга нарыг компьютер техник тоног төхөөрөмжөөр хангах* 111.0 сая төгрөгийн төсөл нь тендер шалгаруулалт удааширсан болон цар тахлын үеийн хилийн хорио цээрийн байдлаас шалтгаалан хугацаа сунгах гэрээ байгуулснаар тайлант онд багтаж хэрэгжээгүй байна. Санхүүжилтийн хөрөнгийг оны эцэст техник хяналт, барьцаа дансанд төвлөрүүлсэн ба дараа онд гэрээт хугацаанд хэрэгжүүлж, санхүүжилтийг бүрэн олгосон байна.

Хөрөнгө оруулалтын бус шинжтэй дараах ажил нь урсгал байдалтай хэрэгжжээ. Үүнд:

- *Төр, төрийн бус байгууллагуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээний зардал* 85.0 сая төгрөгөөс нийт 77.6 сая төгрөгийг дараах байдлаар зарцуулж, үлдэгдэл 7.3 сая төгрөгийг оны эцэст техник хяналт, барьцаа дансанд төвлөрүүлжээ. Үүнд:
 - /50 захирамжаар *Хүмүүнлэгийн чиглэлээрх төрийн чиг үүргийг аймгийн Улаан загалмайн хороогоор гүйцэтгүүлэх зардалд* 15.0 сая,
 - A/127 захирамжаар Аймгийн Цагдаагийн газрын сургалтын төвийн засварын санхүүжилтэд дэмжлэг 10.8 сая,
 - A/295 захирамжаар Бандида ламтан санд Гэгээнтний сургалтын төлбөрт 15.0 сая,
 - A/309 захирамжаар Хархорины хорих ангийн багаж тоног төхөөрөмжийн үнэ 20.0 сая,

- Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн техник хэрэгслийн үнэ 16.8 сая,

• Аймгийн 90 жилийн ойг угтсан бэлтгэл ажил, зохион байгуулах арга хэмжээний зардал 400.0 сая төгрөгийн төсвийн 391.1 сая төгрөгийг зарцуулсан ба үүнээс 123.3 сая төгрөгийг гүйцэтгэлд үндэслэн гэрээт харилцагчдад шилжүүлсэн бол 68.7 хувь буюу 267.8 сая төгрөгийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн нь ихэвчлэн урьдчилгаа хэлбэрээр олгосон санхүүжилт байна. Тухайн ажлууд ондоо багтаж хэрэгжээгүй нь цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан аймгийн 90 жилийн ойг тухайн онд тэмдэглэхгүй болсонтой холбоотой байна. Энэ хөтөлбөрт 84.6 сая төгрөгөөр батлагдсан “90 жилийн ойн ном хэвлүүлэх” төслийн нээлттэй тендерт шалгарсан “Мөнхийн үсэг” ХХК нь 76.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр гэрээ байгуулсан бөгөөд уг тендерийн хэмнэлтийг аймгийн ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2-т: “Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна. Үлдэгдэл 8.9 сая төгрөгийг оны эцэст техник хяналт, барьцаа дансанд төвлөрүүлсэн байна.

Б.3.2. Хөрөнгө оруулалтаар бий болсон автомашин, их засварыг тухайн байгууллагын бүртгэлд тусгаж, ашиглалтад оруулжээ

Тухайн оны орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын нийт зардлаас хөрөнгийн шинжтэй дараах зүйлсийг тухайн байгууллагын бүртгэлд тусгуулж, бүрэн ашиглаж байна Үүнд:

- Нарийнтээл, Хужирт, Гучин-Ус сумдын болон аймгийн ЗДТГ-ын автомашин 200.0 сая
- Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн барилгын засвар 80.0 сая,
- Аймгийн ЗДТГ-ын барилгын засвар 60.0 сая
- Хархорины хорих ангийн багаж тоног төхөөрөмж 20.0 сая,
- Аймгийн Шүүхийн шинжилгээний албаны лабораторийн техник хэрэгсэл 16.8 сая төгрөг.

Харин Аймгийн 90 жилийн ойг угтсан бэлтгэл ажил, зохион байгуулах арга хэмжээний зардал төслийн хүрээнд Өвөрхангай аймаг анх байгуулагдсан Баянхонгор аймгийн Түйн голын цагаан эрэг хэмээх газарт барьсан 33.0 сая төгрөгийн өртөгтэй дурсгалын хөшөөг бүртгэлд тусгаагүй байна.

Б.4. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч зарим зөрчил давтагдсан байна

“Орон нутгийн төсвийн 2020 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”-т хийсэн аудитаар 2 албан шаардлага, 10 зөвлөмж өгсөн. Үүнээс 2 албан шаардлага, 8 зөвлөмжийг биелүүлж хариуг ирүүлжээ.

Албан шаардлага, зөвлөмжүүдийн биелэлтийг утгаар нь багцалж харуулбал:

- “Хөрөнгө оруулалтын шинж чанартай бус төсөл, арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад оруулж төлөвлөхийг таслан зогсоох” талаар өгсөн албан шаардлагад зөрчлийг таслан зогсоосон талаар хариу ирүүлсэн

нь 2022 онд батлагдсан орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсарган ирүүлснээр нотлогдож байна.

- “Нөөцийн мах бэлтгэн худалдаанд гаргах гэрээний хэрэгжилтийг хангуулж, төсвийн хөрөнгийг хугацаанд нь буцаан төвлөрүүлэх” албан шаардлагыг хэрэгжүүлж, харилцах дансны хуулгыг хавсарган ирүүлжээ.
- “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч нарт хууль тогтоомж, гэрээнд заасны дагуу хариуцлага тооцож, холбогдох арга хэмжээ авч байх” зөвлөмжийг хэрэгжүүлж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний гүйцэтгэлийг ирүүлжээ.
- “Худалдан авах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, гүйцэтгэгчийг нээлттэй, ил тод сонгон шалгаруулж байх”, Тендерийн баримт бичиг, урилга, үнэлгээний дүгнэлтийг бодит байдалд нийцүүлэн хянаж нягталсны дараа албажуулж, хэрэглэгчид бодитой мэдээллийг хүргэж байх” зөвлөмжүүдийг хэрэгжүүлсэн талаар хариуг ирүүлсэн ба энэ алдаа зөрчлүүд орон нутгийн хөрөнгө оруулалтын худалдан авах ажиллагаанд давтан илрээгүй байна.

Харин “Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслэн олгож байх” зөвлөмжийн мөрөөр ирсэн хариунд их засварын ажлын санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон талаар нотлох баримт ирүүлсэн боловч энэ зөрчил нь 2021 онд хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл арга хэмжээний санхүүжилтэд давтан гарсан байна.

ДҮГНЭЛТ

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН 58.5 ХУВЬ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН БУС ШИНЖТЭЙ АРГА ХЭМЖЭЭ БАЙНА

- **Орон нутгийн хөрөнгө оруулалтыг үр ашигтай төлөвлөх ажил хангалтгүй байна**
- **Төсөл арга хэмжээг хэрэгжих боломжтой байдлаар санхүүжилтийг баталж байгаа боловч үр ашигтай төлөвлөх тогтолцоо бүрдээгүй байна**
- **Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагаа хууль, журмын дагуу явагдсан боловч зарим худалдан авалтад сонгон шалгаруулалт зарлаагүй байна**
- **Захиалагч хөрөнгө оруулалтын шинжтэй ажлуудын гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулж, хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлсэн байна**
- **Хөрөнгө оруулалтын шинжтэй төсөл, арга хэмжээний санхүүжилт үр дүнтэй байна**
- **Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч зарим зөрчил давтагдсан байна**

Албан шаардлага

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН
ДАРГА З.БАЛДАННЯМ-д
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 9 дүгээр зүйлийн 9.1, 9.2-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан ӨВА-2022/16-14-ШТА-ГА кодтой төлөвлөгөөний дагуу “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг” -т аудит хийхэд тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар барьсан, 33.0 сая төгрөгийн өртөгтэй дурсгалын хөшөөг бүртгэлд тусгаагүй зөрчил илрэв.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т “Төсвийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгө нь төрийн болон орон нутгийн өмч байна”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Албан шаардлагын дагуу 33.0 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаж, зөрчлийг давтан гаргахгүй байх,

2. Дээрх зөрчлийг арилгаж биелэлтийг 2021 оны 6 дугаар сарын 25-ны дотор Өвөрхангай аймаг дахь Төрийн Аудитын газарт албан тоотоор ирүүлэхийг ОНӨГ-ын дарга З.Балданням, ахлах мэргэжилтэн М.Нинжбадгар нарт хариуцуулав.¹

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АХЛАХ АУДИТОР
АУДИТОР
АУДИТОР

С.ШИЙЛЭГМАА
Б.АВИДЦЭРЭН
П.НОРПИЛ

Акт албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 42.1 Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно